

АЛТАЙН ЗАМ ХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хурлыг 2011 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 11 цаг 00 минутанд “Нью прогресс групп” ХХК-ийн байранд эхлэв.

Ирц: 88.02 хувь

Эхэлсэн цаг: 11 цаг 00 минут

Дууссан цаг: 13 цаг 25 минут

Хуралд хувь нийлүүлэгч: Нью прогресс групп ХХК-ийг төлөөлж Ерөнхийлөгч
С.Балжинням

С.Баянмөнх /Алтайн зам ХК-ийн ТУЗ-ийн дарга/

Хурал зохион байгуулагч: М.Нямдаваа /Ерөнхий захирал-Комиссын дарга/

Т.Отгонбаяр /Комиссын нарийн бичгийн дарга/

ТЭМДЭГЛЭХ НЬ:

“Алтайн зам” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн 2010 оны ээлжит хурлыг 2011 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 11.00 цагаас ТУЗ-ийн санаачлагаар “Нью Прогресс групп” ХХК-ийн байранд хуралдуулав. Хуралд компанийн 88 хувийн хувьцаа эзэмшигч “Нью прогресс групп” ХХК, түүнийг төлөөлж ерөнхийлөгч С.Балжинням хүрэлцэн ирснээр хурлын ирц 88.02 хувь байна. Монгол улсын Компанийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1 дэх заалтыг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцож, хурлыг нээв.

Т.Отгонбаяр: “Алтайн зам” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирсэн Та бүхэнд өдрийн мэнд хүргье. Хувь нийлүүлэгчид хүрэлцэн ирж, хууль болон дүрэмд зааснаар хурлын ирц бүрдсэн тул хурлыг нээж байна.

“Алтайн зам” ХК-ийн Хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэх асуудал:

- 2010 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж, батлах
- Төлөөлөн Удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд дүгнэлт өгөх
- Дүрмийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэх
- ТУЗ-ийн гишүүдийг сонгох

Хурлын дэг: Хэлэлцэх асуудлын дарааллын дагуу асуудлыг хэлэлцэх бөгөөд саналыг тухай бүр нь гаргана. Хурлын хэлэлцэх асуудал дууссаны дараагаар санал хураан шийдвэрлэх зарчмаар хурлыг зохион байгуулах, эцэст нь хурлын шийдвэрийн томъёоллыг танилцуулснаар хурлыг хаана.

Нэг. Хурлын даргыг сонгох

Алтайн зам ХК-ийн Хувь нийлүүлэгчдийн 2010 оны ээлжит хурлын даргаар хувьцаа эзэмшигчид санал гаргаагүй тул хурлын даргаар ТУЗ-ийн дарга С.Баянмөнхийг сонголоо.

Хоёр. Компанийн 2010 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах

Т.Отгонбаяр хурлын н.б. дарга: Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2010 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийг ТУЗ-ийн дарга С.Баянмөнх танилцуулна.

С.Баянмөнх: Монгол улсын дэд бүтцийн салбарын хөгжлийн чиг хандлага, өсөн нэмэгдэж, тэлж буй зах зээлийн эдийн засаг, хүчтэй өрсөлдөгч-бүтээн байгуулагч компаниудын менежментийн бодлого, салбарын хүрээнд тавигдах хэрэгцээ, шаардлага нь Алтайн зам ХК-ийн бизнесийн гадаад орчныг эрс өөрчилж, бүтээн байгуулалтын чадавхийг нэмэгдүүлэхийг шаардах болов.

Компани өөрийн материаллаг бааз, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, машин механизмын бааз суурийг өргөтгөж, хуучин ажиллаж байсан дадлага туршлатай боловсон хүчний нөөцийг улам бэхжүүлэн, оновчтой менежментээр ханган ажиллах зорилтыг 2010 онд дэвшүүлэн ажиллаж үйлдвэрлэл, бүтээн байгуулалтынхаа хэмжээг тодорхой хэмжээнд өсгөн нэмэгдүүлж чадсан байна.

Алтайн зам ХК 2010 онд нийт 9,535,722,492.98 төгрөгийн борлуулалттай, үйлдвэрлэлийн 6,912,110,258.66 төгрөгийн өртөгтэй, үйл ажиллагааны 346,151,609.08 төгрөгийн зардалтай ажиллаж, орлогын албан татварт 227,434,223.66 төгрөг төлснөөр татварын дараах цэвэр ашгийн хэмжээг 2,039,033,512.90 төгрөгт хүргэн ажиллажээ. Ингэснээр ашигт ажиллагааны түвшинг 58.5 хувьд хүргэсэн байна. Алтайн зам ХК-ийн 2010 оны орлогын төлөвлөгөөний биелэлт нь үндсэндээ авто замын барилга угсралтын ажлын орлогоор хангагдсан байна.

Тайлант онд компани Баян-Өлгий аймгийн Өлгий - Цагааннуур чиглэлийн 40 км, Баян-Өлгий аймгийн Өлгий хот доторх 4.7 км, Ховд аймгийн Ховд хотын 2 км, Хархорин-Цэцэрлэг чиглэлийн 46.9 км, Хархорин-Цэцэрлэг чиглэлийн 29.9 км хатуу хучилттай авто замын барилга угсралтын ажлуудыг тус тус хийж гүйцэтгэсэн бөгөөд зам барилгын ажлын угсралтанд улсын төсөвт суусан ажлыг 100 хувь биелүүлж ажилласан байна.

Монгол улсын зах зээлийн эдийн засгийн багтаамж тэлэх хэрээр бүтээн байгуулалтын ажлууд ихээр өрнөж, энэ хирээр зах зээл дээр авто замын барилга угсралтын компанийн тоо өсч, тэдгээрийн үйл ажиллагаа улам бүр идэвхжиж байна. Энэ нь цаашид компанийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, бизнесийн оновчтой бодлого, стратеги төлөвлөгөөг зохистойгоор хэрэгжүүлэхийг шаардаж байна. Иймд Төлөөлөн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн цаашид компани дэд бүтцийн салбарт барилгын материалын үйлдвэрлэлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Компанийн хувьд 3 асфальто бетон завод болон жилд 1000 - 1500 тн төмөр бетон эдлэл үйлдвэрлэх чадавхитай үйлдвэрлэлийнхээ дотоод нөөц боломжийг бүрэн хэмжээгээр ашиглаж, барилгын материалын түүхий эдийг зах зээлд нийлүүлэхийг чухалчилж байна.

Компани асфальт болон хайрган хучилттай замын барилга угсралт, засвар, асфальт бетон хольцын үйлдвэрлэл, төмөр бетон болон модон гүүрийн угсралт, засвар, төмөр бетон хийцийн үйлдвэрлэл, гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бөгөөд цаашид өөрийн үйл ажиллагааны цар хүрээг

нэмэгдүүлж, зах зээлээ тэлэх бодлогыг шат дараатайгаар хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Т.Отгонбаяр: Та бүхэн ТУЗ-өөс компанийн 2009 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлттэй танилцлаа.

Гурав. Компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд дүгнэлт өгөх.

С.Балжинням: Компанийн 2010 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн Удирдах зөвлөлийн дүгнэлттэй танилцлаа. Алтайн зам ХК-ийн хувьцааны хяналтын багцыг эзэмшигч "Нью прогресс групп" ХХК-ийн хувьд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтэнд ямарваа нэг санал болоод шүүмжлэл алга. 2011 онд хийх ажлуудаа оновчтой төлөвлөж, өглөг авлага барагдуулах ажлыг хангалттай зохион байгуулахыг зөвлөж байна.

С.Баянмөнх: Хувьцаа эзэмшигчийн саналыг хүлээж авлаа. 2010 онд үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг хичээх болно.

С.Балжинням: Хувьцаа эзэмшигчийн хувьд Төлөөлөн Удирдах зөвлөл болоод Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг хангалттай гэж дүгнэж, бүрэн эрхээ цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийг даалгаж байна. ТУЗ-ийн гишүүн Л.Болд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон тул ТУЗ-ийн үүрэгт ажлаас чөлөөлж Б.Энхбатыг ТУЗ-ийн гишүүнээр сонгож байна.

Дөрөв. Дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэж, батлах эсэх

Т.Отгонбаяр: Компанийн одоо хүчин төгөлдөр үйлчилж буй дүрмийн зарим нэг заалтыг хасч, агуулгыг баяжуулах үүднээс дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж байна. Дүрмийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах өөрчлөлтийг тусгасан болно. Үүнд:

- Компанийн Хувь нийлүүлэгчдийн хурал болон Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэх асуудлуудыг хууль тогтоомжид нийцүүлэн тодорхойлж, тэдгээр асуудлыг шийдвэрлэх саналын квотыг тогтоож өгсөн.
- Хувь нийлүүлэгчдийн хурал зарлах процедурыг дүрмийн төсөлд тодорхой тусгасан.
- Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтын талаарх зохицуулалтыг тусгаж өгсөн.
- Үзэл баримтлалын хувьд хувьцаа эзэмшигчдийн тэгш эрхийг хангахыг энэхүү дүрмийн төсөлд чухалчилсан болно.

С.Балжинням: Хувьцаа эзэмшигчдэд хүргүүлсэн хурлын материалд дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг оруулсан байсантай танилцсан. Компанийн удирдлагын зүгээс санаачлага гаргасан явдлыг сайшааж байна.

Хувьцаа эзэмшигч Нью прогресс групп ХХК-ийн хувьд одоо үйлчилж буй дүрмийг хэвээр хадгалах хүсэлтэй байгаа учраас дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг батлахаас татгалзаж байна.

Хэлэлцэж буй асуудлаар санал хураагаад хурлаас:

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Алтайн зам ХК-ийн Хувь нийлүүлэгчдийн хурал 2011 оны 04-р сарын 27-ны өдрийн 11 цаг 00 минутаас 13 цаг 25 минутанд Улаанбаатар хот, СХД, 4-р хороо, Толгойтын /18101/ гудамжны ХД 59 тоот, Нью Прогресс группын байр, хурлын танхимд хуралдаад:

1. ТУЗ-ийн 2010 оны компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийг батлах.
2. Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүнээр С.Балжинням, С.Баянчулуун, М.Нямдаваа, Э.Өлзийхутаг, С.Баянмөнх, Ц.Гансүх, Д.Зоригт, Х.Болд Б.Энхбат нарыг дахин сонгох.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Нарийн бичиг Л.Цэвэл Л.Цэвэл
гарын үсэг

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Төлөөлөн удирдах
зөвлөлийн дарга С.Баянмөнх С.БАЯНМӨНХ
гарын үсэг

Хурал зохион байгуулах
комиссын дарга М.Нямдаваа М.НЯМДАВАА
гарын үсэг

Хурал зохион байгуулах
комиссын нарийн дарга Т.Отгонбаяр Т.ОТГОНБАЯР
гарын үсэг

Хувьцаа эзэмшигч:

“Нью Прогресс Групп” ХХК-ийг төлөөлж:

Ерөнхийлөгч С.Балжинням С.БАЛЖИННЯМ
гарын үсэг